



# ОТАГ

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### “ОРХОН АЙМГИЙН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ”



**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 3016,5 сая төгрөгөөр давуулан биелүүлэн, төсвийн урсгал зардлыг 735.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулжээ.**

Орхон аймаг  
2018 он

<b>Аудитын тайланг бэлтгэсэн:</b>		<b>АГУУЛГА</b> Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:	2 3-4
<b>Орхон аймаг дахь Төрийн аудитын газар</b>		<b>Бүлэг-1. Орон нутгийн төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, хянах шаардлагатай байна.</b>	5-11
Дарга, Тэргүүлэх аудитор :	Ц.Нармандах	➤ Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн байна.	5-8
		➤ Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 сарын 17-ны өдрийн 5/03 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн төсөвт хийсэн тодотгол нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дах хэсгийн заалтуудтай нийцэхгүй байна.	8-11
Аудитын менежер:	Б.Эрдэнэ	➤ Орон нутгийн төсвийн тэнцлийг алдагдалгүй байхаар төлөвлөжээ.	11
Аудитор	Г.Оргилмөрөн	<b>Бүлэг-2. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 3016,5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 4 нэр төрлийн татварын орлого 2,4-46,8 хувиар буюу 1321,4 төгрөгөөр тасарсан байна.</b>	12-14
Гэрээт аудитор	С.Үнэнхүү	➤ Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээг бүрэн авч ажиллажээ.	12
2018 оны 4 дүгээр сар		➤ Татварын орлогыг 44,562.9 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 47,579.3 сая төгрөгийн орлого төвлөрч 3,016.5 сая төгрөгөөр давж биелэн гүйцэтгэл 106.8%-тай байна.	13-14
Уг тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү.		➤ Орлогын бүх гүйлгээ тухайн төсвийн захирагчийн төрийн сангаар дамжин хийгдсэн байна.	14
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж, тодруулах, лавлах зүйл байвал 70353088, 70350757, 70355805 дугаарын утсаар харилцана уу.		<b>Бүлэг-3. Аймгийн 2017 оны төсвийн урсгал зардлыг нийт 4,367.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон ба гүйцэтгэлээр 735.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулжээ</b>	14-20
		➤ Төсвийн зарлага гүйцэтгэл 735.5 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулагдсан байна.	14-20
		➤ Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн МОН-2301 төслийн зээл 7446.7 сая төгрөгийн өглөгийг үлдэгдэлтэй байна.	20
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар		<b>Дүгнэлт, Зөвлөмж</b>	21-22
		<b>Холбогдох байгууллагын санал</b>	23
		<b>Тэргүүлэх аудиторовын тушаал</b>	24
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон			

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ҮХЭХ	Үл хөдлөх эд хөрөнгө
ОУВС	Олон улсын валютын сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ОАТ	Орлогын албан татвар
ААН	Аж ахуй нэгж
ГБХЗЗГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХББЗА	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ТББ	Төрийн бус байгууллага
БСУГ	Боловсрол соёл урлагын газар
ЗД	Засаг дарга

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудитор 2018 онд Үндэсний аудитын газраас нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

**Аудитын зорилт:** Орхон аймгийн 2017 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гарган холбогдох албан тушаалтан болон ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
2. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл
3. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

**Аудитын хамрах хүрээ:** Аудитыг орон нутгийн төсөв, ТЕЗ-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2017 оны санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудит хийв.

**Аудитын арга зүй:** Аудитыг гүйцэтгэхдээ АОУС, АДБОУС 300, 3000-3100, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:** Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Орон нутгийн төсвийг баталсан АИТХ-ын тогтоолууд,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

**Аудит хийх бүрэлдэхүүн:** Аудитыг Орхон аймгийн тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Оргилмөрөн, гэрээт аудитор С.Үнэнхүү нар хийж гүйцэтгэв.

**Аудитын тайлан, баталгаажуулалт:** Тайлангийн төслийг 2018 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 20-ны өдрүүдэд боловсруулж, төслийг аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нарт 2017 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн албан тоотоор хүргүүлэн, аймгийн Засаг дарын 1/1273 тоотоор санал авсан.

**Үндсэн мэдээлэл:**

Орхон аймгийн 2017 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9 дэх заалтуудын дагуу 2017 онд жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлдээ аудит хийлгэх, аймгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд тайлангаа нэгтгүүлдэг Төрийн сан болон аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, Засаг даргын нөөц сан, орон нутгийн хөгжлийн сан, нийгмийн халамжийн сан, орон нутагт хэрэгжүүлж байгаа сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, байгаль хамгаалах сан, Эрдэнэт сан, орон нутгийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, төсвийн байгууллагууд, тусгай зориулалтын шилжүүлэгтэй ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв нийт аймгийн хэмжээгээр 94 байгууллагуудыг санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд Орхон аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 41,764.5 сая төгрөг, суурь зарлагыг 16,005.3 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 12,466.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд 2 удаа нэмэлт өөрчлөлт орж Орхон аймагт олгох тусгай зориулалтын шилжүүлэг 33,489.4 сая төгрөг, ОНХНС болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 1,941.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээ 1,006.3 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 13,393.2 сая төгрөг болж тус тус өөрчлөгдөж батлагдсан байна.

2017 оны төсвийн орлогыг Аймгийн ИТХ-ийн 2016 оны 12-р сарын 05-ны өдрийн хуралдаанаар 44,409.4 сая төгрөгөөр баталсан байна. 2017 онд аймгийн ИТХ-аар төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тодотголыг 3 удаа хийж, орон нутгийн нийт орлогыг 44,562.8 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлагын төлөвлөгөө 92,964.27 сая төгрөг, гүйцэтгэлээр 89,123.13 сая төгрөг зарцуулж, 3,841.14 сая төгрөг хэмнэж, 95.87 хувийн биелэлттэй ажиллажээ

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлагын 79.8 хувь буюу 71,120.0 сая төгрөгийг урсгал зардал, 20.2 хувь буюу 18,003.5 сая төгрөгийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийн 28.64 хувийг цалин хөлсний зардал, 3.17 хувийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 2.71 хувийг тогтмол зардал, 1.25 хувийг хангамж бараа материалын зардал, 2.35 хувийг нормативт зардал, 0.60 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.13 хувийг томиллолт, зочны зардал, 7.65 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, 3.48 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.87 хувийг хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, 28.95 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн урсгал зардал өмнөх оноос 6,697.25 сая төгрөгөөр өссөн бол хөрөнгийн зардал 12,226.52 сая төгрөгөөр буурч нийт төсвийн зардал өмнөх оноос 5,529.27 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 13,393.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

**Бүлэг.1 Орон нутгийн төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, хянах шаардлагатай байна.**

Аймгийн СТСХ нь 2017 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол, аймгийн эдийн засаг, нийгмийн 2017 онд хөгжүүлэх зорилт зэргийг баримтлан боловсруулахдаа орон тоонд өөрчлөлт оруулаагүй, мөрдөгдөж байгаа хуулиудад орсон өөрчлөлтүүдийг тусгаснаараа онцлог байна.

Орхон аймаг 2017 онд аймгийн ИТХ-аар төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тодотголыг 3 удаа хийж, нийт орлогыг 1,213.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлого 159.0 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 350.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 700.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж буй байгууллагын өөрийн орлого 4.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна.

**1.1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн байна.**

УИХ-аас баталж, Сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2017 оны Орхон аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогыг 41,764.6 сая төгрөг, урсгал орлогыг 41,299.6 сая төгрөг, татварын орлогыг 40,790.1 сая төгрөгөөр хянасныг аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нийт орлогыг 44,488.9 сая төгрөг, урсгал орлогыг 44,023.9 сая төгрөг, татварын орлогыг 43,494.4 сая төгрөг болгон орлогыг 2,724.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

*/Орлого төлөвлөлт нэр төрлөөр харуулбал/ /сая төгрөгөөр/*

ЗАРДЛЫН ТӨРӨЛ		УИХ-аар баталсан нийт орлого	ӨӨРЧЛӨЛ Т	2016.12.02 тоот тогтоол	АИТХ-аар баталсан суурь орлого	Зөрүү
Нийт орлого		41,764.6	2,724.4	44,488.9	40,688.9	2,724.37
Урсгал орлого		41,299.6	2,724.4	44,023.9	40,223.9	2,724.37
<b>1</b>	<b>Татварын орлого</b>	40,790.1	2,704.4	43,494.5	39,694.5	2,704.37
<b>2</b>	<b>Орлогын албан татвар</b>	26,434.6	2,204.4	28,639.0	28,639.0	2,204.37
<b>3</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	28,934.6	2,204.4	31,139.0	31,139.0	2,204.37
3.1	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	27,303.6	2,204.4	29,508.0	29,508.0	2,204.37
3.2	Үйл ажиллагааны орлого	370.0	-	370.0	370.0	-
3.3	Хөрөнгө борлуулсны орлого /ҮХЭХ борлуулсны 2%-н татвар /	850.0	-	850.0	850.0	-
3.4	Бусад орлого / Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар/	-	-	-	-	-
<b>4</b>	<b>Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татвар</b>	411.0	-	411.0	411.0	-
<b>5</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	(2,500.0)	-	(2,500.0)	(2,500.0)	-

6	<b>Өмчийн татвар</b>	5,010.5	500.0	5,510.5	5,510.5	500.00
6.1	Үл хөдлөх эд хөрөнгийн татвар / 0.6% болон иргэдийн өмчилж авсан газрын татвар/	5,000.0	500.0	5,500.0	5,500.0	500.00
6.2	Бууны албан татвар	10.5	-	10.5	10.5	-
7	<b>Дотоодын бараа үйлчилгээний албан татвар</b>	702.0	-	702.0	702.0	-
7.1	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	702.0	-	702.0	702.0	-
8	<b>Бусад татвар /төлбөр хураамж /</b>	310.0	-	310.0	310.0	-
8.1	Улсын тэмдэгтийн хураамж	310.0	-	310.0	310.0	-
9	<b>Газрын төлбөр</b>	8,300.0	-	8,300.0	4,500.0	-
9.1	Газрын төлбөр	8,300.0	-	8,300.0	4,500.0	-
10	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	33.0	-	33.0	33.0	-
10.1	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	9.0	-	9.0	9.0	-
10.2	Ус, рашаан ашигласны төлбөр	21.0	-	21.0	21.0	-
10.3	Ойн нөөц ашигласны төлбөр	3.0	-	3.0	3.0	-
11	<b>Татварын бус орлого</b>	509.5	20.0	529.5	529.5	20.00
11.1	Төсөвт байгууллагын өөрийн орлого	59.5	20.0	79.5	79.5	20.00
11.2	Хүү, торгуулийн орлого	450.0	-	450.0	450.0	-
12	<b>Хөрөнгийн орлого</b>	-	-	-	-	-
12.1	Хөрөнгө борлуулсны орлого	-	-	-	-	-
13	<b>Хог хаягдлын үйлчилгээний хураамж</b>	465.0	-	465.0	465.0	-

Сангийн яамнаас хянасан тоог нэмэгдүүлэн батлахдаа Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг 2,204.3 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн татварын / 0.6% болон иргэдийн өмчилж авсан газрын татвар/ орлогыг 500.0 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 20.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

2017 оны 05-р сарын 26-нд хийсэн тодотголоор Бусад орлого / Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар/ - ыг 1,505.4 сая төгрөгөөр, Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 5.6 сая төгрөгөөр, нийт 1,511.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бол 2017 оны 12-р сарын 01-нд хийсэн тодотголоор нийт орлогыг 1,352.0 сая төгрөгөөр бууруулан батлахдаа Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг 1,073.5 сая төгрөг, Бусад орлого / Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар/-ыг 578.5 сая төгрөгөөр тус тус бууруулсан ба Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 300.0 мянган төгрөгөөр бууруулжээ.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн тодотголоор 2017 оны төсвийн нийт орлогыг 80,253.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс орон нутгийн

төсвийн орлого 44,647.9 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 1,956.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 33,489.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж буй байгууллагын өөрийн орлого 159.5 сая төгрөгөөр тус тус батлан анх баталснаас нийт орлогыг 1,213.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлогыг 159.0 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 350.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийг 700.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж буй байгууллагын өөрийн орлогыг 4.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

*/Орон нутгийн төсвийн орлогод тодотгол хийсэн дүн/ /сая төгрөгөөр/*

ЗАРДЛЫН ТӨРӨЛ		АИТХ-аар баталсан нийт орлого			Зөрүү		
		2016.12.02 02 тоот тогтоол	2017.05.26 7/05 тоот тогтоол	2017.12.01 09/02 тоот тогтоол	/4-3/	/5-3/	/5-4/
1	2	3	4	5	6	7	8
	Нийт орлого	44,488.9	45,999.94	44647.9	1,511.0	159.0	(1,352.0)
	Урсгал орлого	44,023.9	45,534.94	44182.9	1,511.0	159.0	(1,352.0)
<b>1</b>	<b>Татварын орлого</b>	43,494.5	44,999.87	43647.9	1,505.4	153.4	(1,352.0)
<b>2</b>	<b>Орлогын албан татвар</b>	28,639.0	30,144.37	28792.4	1,505.4	153.4	(1,352.0)
<b>3</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	31,139.0	32,644.37	30992.4	1,505.4	(146.6)	(1,652.0)
3.1	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	29,508.0	29,507.95	28434.4	0.0	(1,073.5)	(1,073.5)
3.2	Үйл ажиллагааны орлого	370.0	370.00	370.0	-	-	-
3.3	Хөрөнгө борлуулсны орлого /ҮХЭХ борлуулсны 2%-н татвар /	850.0	850.00	850.0	-	-	-
3.4	Бусад орлого / Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар/	-	1,505.41	927.0	1,505.4	927.0	(578.5)
4	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татвар	411.0	411.00	411.0	-	-	-
<b>5</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	(2,500.0)	(2,500.00)	-2200.0	-	300.0	300.0
<b>6</b>	<b>Өмчийн татвар</b>	5,510.5	5,510.50	5510.5	-	-	-
6.1	Үл хөдлөх эд хөрөнгийн татвар / 0.6% болон иргэдийн өмчилж авсан газрын татвар/	5,500.0	5,500.00	5500.0	-	-	-
6.2	Бууны албан татвар	10.5	10.50	10.5	-	-	-
<b>7</b>	<b>Дотоодын бараа үйлчилгээний албан татвар</b>	702.0	702.00	702.0	-	-	-
7.1	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	702.0	702.00	702.0	-	-	-
<b>8</b>	<b>Бусад татвар /төлбөр хураамж /</b>	310.0	310.00	310.0	-	-	-
8.1	Улсын тэмдэгтийн хураамж	310.0	310.00	310.0	-	-	-
<b>9</b>	<b>Газрын төлбөр</b>	8,300.0	8,300.00	8300.0	-	-	-
9.1	Газрын төлбөр	8,300.0	8,300.00	8300.0	-	-	-



10	Байгалийн нөөц ашигласны төлбөр	33.0	33.00	33.0	-	-	-
10.1	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	9.0	9.00	9.0	-	-	-
10.2	Ус, рашаан ашигласны төлбөр	21.0	21.00	21.0	-	-	-
10.3	Ойн нөөц ашигласны төлбөр	3.0	3.00	3.0	-	-	-
11	Татварын бус орлого	529.5	535.08	535.1	5.6	5.6	-
11.1	Төсөвт байгууллагын өөрийн орлого	79.5	85.08	85.1	5.6	5.6	-
11.2	Хүү, торгуулийн орлого	450.0	450.00	450.0	-	-	-
12	Хөрөнгийн орлого	-	-	0.0	-	-	-
12.1	Хөрөнгө борлуулсны орлого	-	-	0.0	-	-	-
13	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	465.0	465.00	465.0	-	-	-

Татварын хувь хэмжээ өөрчлөгдөөгүй, цалин нэмэгдээгүй байхад цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар 2016 оны гүйцэтгэлээр 28,210.7 сая төгрөг орсон байхад 29,508.0 сая төгрөгөөр батлан үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн ба 2017 оны 12-р сарын 01-ны тодотголоор 28,434.4 сая төгрөг болгон 1,073.5 сая төгрөгөөр бууруулан баталсан.

Бусад орлого “Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар” -ыг оны эхэнд төлөвлөөгүй ба 2017 оны 05-р сарын 26-нд хийсэн тодотголоор 1,505.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн боловч 2017 оны 12-р сарын 01 нд хийсэн тодотголоор 927.0 сая төгрөг болгон 578.5 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Мөн хувь хүний орлогын албан татварын буцаан олголт 2016 оны гүйцэтгэлээр 2,398.2 сая төгрөг байхад анх 2,500.0 сая төгрөгөөр баталсан боловч 2017 оны 12-р сарын 01 нд хийсэн тодотголоор 2,200.0 сая төгрөг болгон 300.0 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Дээрхээс үзэхэд: 2017 оны төсвийн төслийг тооцоо судалгаагүйгээр боловсруулж, татварын хувь хэмжээ өөрчлөгдөөгүй, цалин нэмэгдээгүй байтал орон нутгийн төсвийн орлогыг өсгөж тооцоолон төсвийн орлогод тодотгол хийгдсэн байна.

**1.2 Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 сарын 17-ны өдрийн 5/03 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн төсөвт хийсэн тодотгол нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудтай нийцэхгүй байна.**

УИХ-аас баталж, сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2017 оны аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогыг 41,764.6 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 1,606.6 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлэг 32,788.9 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого 155.3 сая төгрөг нийт орлого 76,315.4 сая төгрөгөөр хянасныг аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 тоот тогтоолоор нийт орлогыг 44,488.9 сая төгрөг болгон 2,724.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Харин 2017 оны аймгийн орон нутгийн төсвийн нийт зардлыг 76,315.4 сая төгрөгөөр хянасныг 79,039.8 сая төгрөг болгон нэмэгдүүлэхдээ Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсвийн зардлыг 386.3 сая төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн зардлыг 2,214.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 123.3 сая төгрөг нийт 2,274.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

/Батлагдсан орлого, зардал сая төгрөгөөр/

д/д	Санхүүжүүлэх байгууллага нэр	УИХ-аар баталсан	АИТХ-аас баталсан 2016.12.02-ны 02 тоот тогтоол	Өөрчлөлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	153.4	539.6	386.3
2	Засаг дарга	14571.5	16786.4	2214.9
3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	1760.1	1760.1	0.0
4	Орон нутгийн хөрөнгө оруулалт	10499.3	10622.6	123.3
5	Автозамын сан	607.7	607.7	0.0
6	Байгаль хамгаалах сан	672.7	672.7	0.0
7	Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс зарцуулах хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр		0.0	0.0
8	Баян-Өндөр сум хөгжүүлэх сан		0.0	0.0
9	Жаргалант сум хөгжүүлэх сан		0.0	0.0
10	ОНХС-аас олгох сум	2640.2	2640.2	0.0
11	ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ	11313.0	11313.0	0.0
12	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	18310.7	18310.7	0.0
13	СУМЫН ЭМНЭЛЭГ	283.9	283.9	0.0
14	БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР	268.1	268.1	0.0
15	ОРОН НУТГИЙН МУЗЕЙ	98.4	98.4	0.0
16	ОРОН НУТГИЙН НОМЫН САН	220.8	220.8	0.0
17	ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ТЕАТР	375.4	375.4	0.0
18	СУМДЫН СОЁЛЫН ТӨВ	297.8	297.8	0.0
19	ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР	225.5	225.5	0.0
20	ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС	218.8	218.8	0.0
21	ӨРХИЙН ЭМНЭЛЭГ	1331.7	1331.7	0.0
22	Улсын төсөвт төвлөрүүлэх	12466.3	12466.3	0.0
<b>САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>76315.4</b>	<b>79039.8</b>	2724.4
1	Нийт орлого	41,764.6	44,488.9	2,724.4
2	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,606.6	1,606.6	-
3	Тусгай зориулалтын шилжүүлэг	32,788.9	32,788.9	-
4	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	155.3	155.3	-
5	Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл			-
6	Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл			-
7	Сумдын сум хөгжүүлэх сангийн орлого			-
<b>ОРЛОГО БУЮУ ЭХ ҮҮСВЭР ДҮН</b>		<b>76,315.4</b>	<b>79,039.8</b>	<b>2,724.4</b>

УИХ-ын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 2017 оны төсвийг ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээтэй холбогдуулан төсөвт тодотгол хийсэн дагуу Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар

сарын 01-ны өдрийн өдрийн хуралдааны 09/02 тоот тогтоолоор төсвийн нийт орлогыг 44,647.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 1,956.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 33,489.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого 159.5 сая төгрөг, орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл 9,445.3 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 607.2 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн орлого 310.0 сая төгрөг нийт орлого 90,855.8 сая төгрөг болгон нийт орлогыг 1,352.0 сая төгрөгөөр бууруулан, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 15.2 сая төгрөг, тусгай зориулалт шилжүүлгийн орлогыг 687.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлогыг 4.2 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн орлогыг 240.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн өдрийн хуралдааны 09/02 тоот тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн нийт зардлыг 90,855.8 сая төгрөгөөр баталж 405.3 сая төгрөгөөр бууруулахдаа аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн зардлыг 469.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 128.7 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 578.5 сая төгрөгөөр тус тус бууруулан тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг 691.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Мөн улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 12,466.2 сая төгрөгөөр баталсан бол УИХ-ын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор 13,393.2 сая төгрөг болгон 927.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Дээрхи 2 удаа хийсэн тодотгол нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 34.2.1 “дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалт, Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголыг үндэслэн хийгдсэн байна.

## /Төсвийн зардлын төлөвлөлт, сая төгрөгөөр/

Д/Д	Санхүүжүүлэх байгууллага нэр	Тодотгол хийсэн			Тодотгол хийсэн		Тодотгол хийсэн	
		2016.12.02 2 02 тоот тогтоол	2017.02.17 5/03 тоот тогтоол	Өөрч лөлт	2017.05.26 7/05 тоот тогтоол	Өөрч лөлт	2017.12.01 09/02 тоот тогтоол	Өөрч лөлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	539.6	620.5	80.9	620.5	0.0	620.5	0.0
2	Засаг дарга	16786.4	18795.6	2009.3	18801.2	5.6	18331.7	-469.6
3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	1760.1	2136.7	376.6	2136.7	0.0	2151.9	15.2
4	Орон нутгийн хөрөнгө оруулалт	10622.6	10736.5	114.0	10736.5	0.0	10607.8	-128.7
5	Автозамын сан	607.7	607.7	0.0	607.7	0.0	607.7	0.0
6	Байгаль хамгаалах сан	672.7	752.8	80.1	752.8	0.0	752.8	0.0
7	Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс зарцуулах хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр	0.0	7161.1	7161.1	7161.1	0.0	6985.8	-175.3
8	Баян-Өндөр сум хөгжүүлэх сан	0.0	230.0	230.0	230.0	0.0	450.0	220.0
9	Жаргалант сум хөгжүүлэх сан	0.0	80.0	80.0	80.0	0.0	100.0	20.0
10	ОНХС-аас олгох сум	2640.2	2870.9	230.6	3205.6	334.7	3205.6	0.0
11	ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ	11313.0	11363.0	50.0	11358.6	-4.3	11570.7	212.1
12	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	18310.7	18310.7	0.0	18290.1	-20.7	18693.7	403.6
13	СУМЫН ЭМНЭЛЭГ	283.9	283.9	0.0	283.9	0.0	309.7	25.8
14	БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР	268.1	268.1	0.0	268.1	0.0	275.9	7.8
15	ОРОН НУТГИЙН МУЗЕЙ	98.4	98.4	0.0	98.4	0.0	101.4	3.0

16	ОРОН НУТГИЙН НОМЫН САН	220.8	220.8	0.0	218.3	-2.5	226.6	8.3
17	ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ТЕАТР	375.4	375.4	0.0	369.6	-5.8	382.8	13.2
18	СУМДЫН СОЁЛЫН ТӨВ	297.8	297.8	0.0	294.3	-3.6	300.8	6.6
19	ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР	225.5	225.5	0.0	225.5	0.0	230.3	4.8
20	ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС	218.8	218.8	0.0	218.8	0.0	225.1	6.3
21	ӨРХИЙН ЭМНЭЛЭГ	1331.7	1331.7	0.0	1331.7	0.0	1331.7	0.0
22	Улсын төсөвт төвлөрүүлэх	12466.3	12466.3	0.0	13971.7	1505.4	13393.2	-578.5
<b>САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>79039.8</b>	<b>89452.2</b>	10412.5	<b>91261.1</b>	<b>1808.9</b>	<b>90855.8</b>	<b>-405.3</b>
1	Нийт орлого	44,488.9	44,488.9	0.0	45,999.9	1,511.0	44,647.9	(1,352.0)
2	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,606.6	1,606.6	-	1,941.3	334.7	1,956.5	15.2
3	Тусгай зориулалтын шилжүүлэг	32,788.9	32,838.9	50.0	32,802.1	(36.9)	33,489.4	687.3
4	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	155.3	155.3	-	155.3	-	159.5	4.2
5	Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл		9,445.3	9,445.3	9,445.3	-	9,445.3	-
6	Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл		607.2	607.2	607.2	-	607.2	-
7	Сумдын сум хөгжүүлэх сангийн орлого		310.0	310.0	310.0	-	550.0	240.0
<b>ОРЛОГО БУЮУ ЭХ ҮҮСВЭР ДҮН</b>		<b>79,039.8</b>	<b>89,452.2</b>	<b>10,412.5</b>	<b>91,261.1</b>	<b>1,808.9</b>	<b>90,855.8</b>	<b>(405.3)</b>

Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 сарын 17-ны өдрийн 5/03 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл 9,445.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 607.2 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн орлого 310.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 50.0 сая төгрөгөөр, орлогыг 10,412.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн орон нутгийн төсөвт тодотгол хийжээ.

Дээрхи тодотголоор нэмэгдүүлсэн зарлагыг авч үзвэл орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 376.6 сая төгрөгөөр, ОНХС-ийн зардлыг 4,100.0 сая төгрөгөөр, аймгийн Засаг даргын багцын зардлыг 2,009.3 сая төгрөг, Орон нутгийн шилжих үлдэгдлээс зарцуулах хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр зардлыг 7,161.1 сая төгрөг, аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 80.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 сарын 17-ны өдрийн 5/03 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн төсөвт хийсэн тодотгол нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудтай нийцэхгүй байна.

### 1.3 Орон нутгийн төсвийн тэнцлийг алдагдалгүй байхаар төлөвлөжээ.

2017 онд орон нутгийн төсвийг 3 удаа тодотгож, орон нутгийн нийт орлогыг 80,253.3 сая төгрөг, нийт зардлыг 90,855.8 сая төгрөг, нийт тэнцлийг 10,602.5 сая төгрөгийн алдагдалтай байхаар баталсан бөгөөд түүнийг нөхөх эх үүсвэрийг орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл 9,445.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 607.2 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн орлого 310.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

**Бүлэг.2 Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 3016,5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 4 нэр төрлийн татварын орлого 2,4-46,8 хувиар буюу 1321,4 төгрөгөөр тасарсан байна.**

**2.1. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээг бүрэн авч ажиллажээ.**

Орхон аймаг 2017 оны төсвийн орлогыг Аймгийн ИТХ-ийн 2016 оны 12-р сарын 02-ны өдрийн хуралдаанаар 44,409.4 сая төгрөгөөр баталсан байна. 2017 онд аймгийн ИТХ-аар төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тодотголыг 3 удаа хийж, орон нутгийн нийт орлогыг 44,562.8 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг 1,073.5 сая төгрөгөөр, ХХОАТ-ын буцаалтыг 300.0 сая төгрөгөөр тус тус бууруулж хадгаламжийн хүүгийн орлогыг 926.9 сая төгрөгөөр шинэчлэн тус тус баталсан байна.

Татварын орлогыг 44,562.9 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 47,579.3 сая төгрөгийн орлого төвлөрч 3,016.5 сая төгрөгөөр давж биелэн гүйцэтгэл 106.8%- тай байна.

Аймгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төлөөр авч үзвэл 13 нэр төрлийн татварын орлого 121.3-2604.4 хувь буюу 4,328.9 сая төгрөгөөр давж биелэн, 4 нэр төрлийн татварын орлого 2.4-46.8 хувиар буюу 1,321.4 сая төгрөгөөр тасарсан байна.

15 нэр төрлийн орлого төрийн сангийн 35 дансаар дамжин орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрчээ.

**Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:(сая.төгрөг)**

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Нийт орлого	Зөрүү	Хувь
	910-Эхний үлдэгдэл		9472.9		
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	28434.4	27748.8	(685.6)	97.6
2	Үйл ажиллагааны орлого	370.0	196.7	(173.3)	53.2
3	Шууд бус орлого	411.0	922.3	511.3	224.4
4	Хадгаламжийн хүү.орлого	927.0	716.2	(210.7)	77.3
5	Хөрөнгө борлуулсны орлого	850.0	598.2	(251.8)	70.4
6	Үл хөдлөх хөрөнгийн татвар	5500.0	6931.5	1431.5	126.0
7	Бууны татвар	10.5	36.6	26.1	349.0
8	АТБӨЯХАТатвар	702.0	851.5	149.5	121.3
9	Улсын тэмдэгтийн хураамж	310.0	396.9	86.9	128.0
10	ТТАМ-н ОАТ	9.0	31.6	22.6	350.8
11	Газрын төлбөр	8300.0	9192.8	892.8	110.8
12	Хог хаягдлын хураамж	465.0	543.5	78.5	116.9
13	Бусад татвар	0.0	119.6	119.6	
14	Ус рашааны нөөц ашигласны	21.0	546.9	525.9	2604.4
15	Ойн нөөц ашигласны	3.0	10.7	7.7	357.0
16	Хүүгийн орлого	0.0	31.1	31.1	
17	Торгуулийн орлого	450.0	895.3	445.3	199.0
18	ХХОАТ-ын буцаалт	-2200.0	-2191.0	9.0	99.6
	<b>ДҮН</b>	<b>44562.9</b>	<b>47579.3</b>	<b>3016.5</b>	<b>106.8</b>

**2.2. Татварын орлогыг 44,562.9 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 47,579.3 сая төгрөгийн орлого төвлөрч 3,016.5 сая төгрөгөөр давж биелэн гүйцэтгэл 106.8%- тай байна.**

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь задлан үзвэл цалин хөлс, үйл ажиллагааны орлого, хадгаламжийн хүүгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого тасарч, бусад орлогууд давж биелсэн байна. Тасарсан орлого тус бүрийн шалтгааныг тогтооход дараах байдалтай байна. Үүнд:

**Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар:**-ын орлогыг 28,434.4 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 27,748.8 сая төгрөг оруулан 685.6 сая төгрөг буюу 2.4 хувиар тасарсан нь орлогыг бүрдүүлэгч гол аж ахуйн нэгж болох "Эрдэнэт Үйлдвэр"ХХК нь 2017 онд гадаад ажилтны тоогоо 50% хүртэл бууруулах арга хэмжээ авсан, мөн ахмад ажилтан тэтгэвэрт гарахад оронд нь шинээр ажилтан авах асуудал нь шийдэгдэхгүй удаашралтай байсан зэргээс шалтгаалан үйлдвэрийн цалингийн сан буурч, төлсөн ХХОАТ буурснаас шалтгаалсан байна.

**Үйл ажиллагааны орлого буюу аж ахуй эрхэлсний орлогын татвар:**-ын орлогыг 370.0 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 196.7 сая төгрөг оруулан 173.3 сая төгрөг буюу 46.8 хувиар тасарсан нь эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, борлуулалт буурсантай холбоотой энэ төрлийн татварын орлого буурч, төлөвлөгөө тасарсан байна.

**Хөрөнгө борлуулсны татварын орлого:** татварыг 850.0 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 598.2 сая төгрөг оруулан 251.8 сая төгрөг буюу 29.6 хувиар тасарсан нь ипотекийн зээл олголт буурч үүнийг дагаад орон сууц, үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурсантай холбоотой тасарчээ.

**Хадгаламжийн хүүгийн орлого:** татварыг 927.0 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 716.2 сая төгрөг оруулан 210.7 сая төгрөг буюу 22.7 хувиар тасарсан нь иргэдийн хадгаламжийн хүүгээс авдаг татварын орлого бөгөөд хууль нь 2017 оны 5-р сараас мөрдөгдөж эхэлсэн.Монгол банкнаас арилжааны банкууд дээр байгаа хадгаламжуудын судалгааг авсан боловч тухайн төрлийн татварын төсвийг өндөр төлөвлөснөөс орлого тасрахад нөлөөлжээ.

**Ус рашааны нөөц ашигласны татвар:** Тайлант онд 21.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээрээ 525.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Орлого өндөр дүнгээр давж биелэх болсон шалтгаан нь Сэлэнгэ голын сав газрын захиргаанаас төлөвлөгөөт шалгалтыг хийж "Эрдэнэт үйлдвэр" ХХК ус бохирдуулсан байхыг тогтоож нөхөн төлбөр тавигдсанаас үүдэн орлого үлэмж хэмжээгээр давсан байна. Үүнийг жил бүр төлөвлөх боломжгүй байна.

2017 онд бэлэн бус торгуулийн системээр давхардсан тоогоор 16014 иргэнд 1,076.2 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн орлогод 512.6 сая төгрөгийн орлого төвлөрч 563.5 сая төгрөгийн орлого ороогүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2013 оны 388 дугаар тогтоолоор баталсан "Бэлэн бус торгуулийн систем нэвтрүүлэх түр журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Зөрчил гаргасан этгээд нь ногдуулсан торгуулийг 15 хоногийн дотор заасан дансанд төлөх үүрэгтэй", 4.2-т "Торгуулийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдол бүрт Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32.3-т заасны дагуу 20.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авна" гэж заасан байна.

Иймд орлогыг тухайн онд орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлж ажиллах бүрэн боломжтой байна.

### 2.3. Орлогын бүх гүйлгээ тухайн төсвийн захирагчийн төрийн сангаар дамжин хийгдсэн байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд төрийн сангийн чиг үүргийг хуульчлан заасны дагуу Орхон аймгийн Төрийн сан, Жаргалант сумын Төрийн сан нь төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу төсвийн байгууллагуудын бүртгэлийн дансыг батлагдсан төсвийн хуваарийн дагуу орлого, зарлагын гүйлгээг хянаж, төлбөр тооцоог гүйцэтгэжээ.

Орон нутгийн өмчит 7 ААН-ийн орлого, зардлын төлбөр тооцоо арилжааны банкаар хийгдэж байна. Харин өрхийн эрүүл мэндийн 11 төв, хувийн сургууль, цэцэрлэгүүдэд олгох санхүүжилт аймгийн Төрийн сангаас тус байгууллагуудын арилжааны банканд дахь харилцах дансанд шилжиж, зарлагын гүйлгээ нь арилжааны банканд дахь харилцах дансаар хийгддэг байна.

### **Бүлэг.3 Аймгийн 2017 оны төсвийн урсгал зардлыг нийт 4,367.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон ба гүйцэтгэлээр 735.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулжээ.**

#### **3.1. Төсвийн зарлагын гүйцэтгэл 735.5 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулагдсан байна.**

Орхон аймгийн 2017 оны төсвийг АИТХ-ын 2016.12.02-ний өдрийн 02 тоот тогтоолоор баталж 2017.02.17-нд мөн 2017.05.26-нд болон 2017.12.01-ний өдрийн 09/02 тоот тогтоолоор тус тус 3 удаа тодотгож баталсан байна.

Нийтдээ 2017 оны төсвийн жилд улсын төсөвт тэгшитгэн төвлөрүүлэх орлогын хэмжээг 926.9 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 700.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Орхон аймгийн ТЭЗ-ийн аудит хийсэн 2017 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөө 92,964.3 сая төгрөг, гүйцэтгэл 89,123.1 сая төгрөг байна.

Төсвийн гүйцэтгэлээр 3,841.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна. 2016 онд орон нутгийн төсвийн зарлага 94,652.7 сая төгрөг байсан бол 2017 онд 5,529.6 сая төгрөгөөр буурчээ.

Нийт зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 3,841.2 сая төгрөгөөр дутуу буюу 95.9 хувийн биелэлттэй байна.

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	2	3	4	5=4-3
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>94,652.76</b>	<b>81,239.49</b>	<b>92,964.30</b>	<b>89,123.13</b>	<b>-3,841.17</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>64,422.74</b>	<b>67,487.29</b>	<b>71,855.08</b>	<b>71,119.63</b>	<b>-735.45</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,073.04	41,963.23	45,196.11	44,543.28	-652.83

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,836.73	24,352.67	25,554.20	25,529.30	-24.90
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,721.21	2,678.80	2,838.92	2,821.90	-17.02
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,372.96	3,067.50	2,547.70	2,417.06	-130.64
Хангамж, бараа материалын зардал	1,014.97	690.87	1,120.64	1,114.80	-5.84
Нормативт зардал	2,103.82	2,404.24	2,101.85	2,090.70	-11.15
Эд хогшил, урсгал засварын зардал	571.91	288.46	537.43	535.90	-1.53
Томилолт, зочны зардал	90.80	100.68	119.20	112.80	-6.40
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,467.17	5,191.54	7,113.72	6,818.23	-295.49
Бараа үйлчилгээний бусад зардал	2,893.47	3,188.47	3,262.45	3,102.59	-159.86
ХҮҮ					0.00
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр					0.00
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр					0.00
ТАТААС	996.87	845.90	803.80	778.35	-25.45
Төрийн өмчит байгууллагад олгох татаас					0.00
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	996.87	845.90	803.80	778.35	-25.45
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,352.83	24,678.16	25,855.17	25,798.00	-57.17
Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,702.62	12,466.26	13,393.20	13,393.20	0.00
Бусад урсгал шилжүүлэг	10,650.21	12,211.90	12,461.97	12,404.80	-57.17
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,230.02</b>	<b>13,752.20</b>	<b>21,109.22</b>	<b>18,003.50</b>	<b>-3,105.72</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>					<b>0.00</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>96,139.83</b>	<b>81,239.49</b>	<b>92,964.30</b>	<b>89,768.08</b>	<b>-3,196.22</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>35,291.19</b>	<b>34,395.55</b>	<b>35,445.90</b>	<b>35,327.19</b>	<b>-118.71</b>
Улсын төсвөөс санхүүжих					0.00
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих					0.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	31,729.16	32,788.90	33,489.40	33,370.50	-118.90
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	3,562.03	1,606.65	1,956.50	1,956.69	0.19
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>57,841.45</b>	<b>44,953.88</b>	<b>54,008.20</b>	<b>51,118.12</b>	<b>-2,890.08</b>
Орон нутгийн төсвөөс	57,841.45	44,953.88	54,008.20	51,118.12	-2,890.08
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих					0.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,571.99</b>	<b>1,580.06</b>	<b>3,050.80</b>	<b>2,889.81</b>	<b>-160.99</b>
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>					0.00
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>435.20</b>	<b>310.00</b>	<b>459.40</b>	<b>432.96</b>	<b>-26.44</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>91</b>	<b>94</b>	<b>94</b>	<b>94</b>	<b>0</b>
Төсвийн байгууллага	81	79	79	79	0
Төсвөөс гадуур байгууллага	10	15	15	15	0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>3,049</b>	<b>3,022</b>	<b>3,022</b>	<b>3,018</b>	<b>-4</b>
Удирдах ажилтан	133	151	151	151	0
Гүйцэтгэх ажилтан	1,936	1,930	1,930	1,901	-29
Үйлчлэх ажилтан	889	865	865	893	28
Гэрээт ажилтан	91	76	76	73	-3
<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО ( жилийн дунджаар )</b>	<b>22,778</b>	<b>22,993</b>	<b>22,993</b>	<b>23,023</b>	<b>30</b>
Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	16,984	16,995	16,995	16,911	-84
СӨБ байгууллагад суралцагч	5,794	5,998	5,998	6,112	114

Төсвийн гүйцэтгэлийн нийт зарлагын 79.8 хувь буюу 71,120.0 сая төгрөгийг урсгал зардал, 20.2 хувь буюу 18,003.5 сая төгрөгийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийн 28.64 хувийг цалин хөлсний зардал, 3.17 хувийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 2.71 хувийг тогтмол зардал, 1.25 хувийг хангамж бараа



материалын зардал, 2.35 хувийг нормативт зардал, 0.60 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.13 хувийг томилолт, зочны зардал, 7.65 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, 3.48 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.87 хувийг хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, 28.95 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн урсгал зардал өмнөх оноос 6,697.25 сая төгрөгөөр өссөн бол хөрөнгийн зардал 12,226.52 сая төгрөгөөр буурч нийт төсвийн зардал өмнөх оноос 5,529.27 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 13,393.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

➤ Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 33,489.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 33,370.5 сая төгрөгийг зарцуулж, 118.9 сая төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна. Зардлын 4.9 хувийг эрүүл мэндийн салбар, 93.8 хувийг боловсролын салбар, бусад 1.3 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оноос 2024.3 сая төгрөгөөр зардал өссөн ба үүний 2,021.7 сая төгрөг нь боловсролын салбарын зардлын өсөлт байна.

Д/д	Байгууллагын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	Батлагдсан Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүнд эзлэх хувь	/сая төгрөгөөр/ Зөрүү	
						Төлөвлө гөөнөөс	Өмнөх оноос
1	Эрүүл мэндийн салбар	1,631.50	1,641.43	1,641.42	4.92	-0.01	9.92
2	Боловсролын салбар	29,262.10	31,392.51	31,283.83	93.75	-108.69	2,021.73
3	ГБХЗХГазар	225	225.09	215.54	0.65	-9.56	-9.46
4	ГХБХБГазар	227.5	230.34	229.67	0.69	-0.67	2.17
	<b>ДҮН</b>	<b>31,346.10</b>	<b>33,489.37</b>	<b>33,370.45</b>	<b>100.00</b>	<b>-118.92</b>	<b>2,024.35</b>

➤ АИТХ-ын 2017.12.01-ний өдрийн 09/02 дугаар тогтоолоор аймгийн халамжийн сангийн төсвийг 605.0 сая төгрөгөөр бууруулж 7,842.8 сая төгрөгөөр баталжээ. Үүнтэй холбоотойгоор халамжийн зардлын эх үүсвэр 389.4 сая төгрөгөөр дутагджээ. Халамжийн сангийн 2016 оны үйл ажиллагааны нийт зардал 8,935.5 сая төгрөг, 2017 оны зардал 8,182.1 сая төгрөг болсон байна. Тайлант онд:

- нийгмийн халамжийн тэтгэвэр , нөхцөлт мөнгөн тэтгэмж 5,044.4 сая төгрөг,
- ахмад настны тусламж үйлчилгээ 665.0 сая төгрөг,
- олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 55.0 сая төгрөг,
- хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээ 346.7 сая төгрөг,
- жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд олгох тусламж 1,106.5 сая төгрөг,
- хүнс тэжээлийн тусламжинд 873.4 сая төгрөг,
- амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдийн урамшуулалд 29.4 сая төгрөг,
- банкны үйлчилгээнд 4.5 сая төгрөгийг тус тус зарцуулж, арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна. Орон нутгийн төсөвт 56.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

➤ 2017 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 18,954.1 сая төгрөгийн 384 ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж, АИТХ-ын 2017оны 12 сарын 01-ний 09 дүгээр тогтоолоор баталсан байна. Үүнийг задалбал: Хөрөнгө оруулалтын 202 ажлын 10607.8 сая төгрөг, шилжих үлдэгдлээр санхүүжигдэх 136 ажлын 6,985.8 сая төгрөг, Байгаль хамгаалах арга хэмжээний

хөрөнгө оруулалтаар 39 ажлын 752.8 сая төгрөг, Авто замын сангаар 7 ажлын 607.6 сая төгрөг тус бүр санхүүжигдэхээр батлагдсан байна. Үүн дотор 136 төсөл хөтөлбөрийн 2,961.4 сая төгрөг байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын 15.6%-ийг эзэлж байна.

Гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын 201 ТАХ-г 8,146.7 сая төгрөг, болзошгүй аваарын зардалд 852.5 сая төгрөг, зураг төсвийн зардалд 495.1 сая төгрөг, техник хяналтын зардалд 208.9 сая төгрөг, шилжих үлдэгдлээр санхүүжигдэх хөрөнгө оруулалт 101 ТАХ-г 5,436.3 сая төгрөг, байгаль хамгаалах арга хэмжээний хөрөнгө оруулалтаар 36 ТАХ-г 546.7 сая төгрөг, авто замын сангаар 7 ТАХ-г 552.2 сая төгрөг санхүүжүүлж нийт 16,238.4 сая төгрөг зарцуулагдсан байна.

Хөрөнгө оруулалтын батлагдсан дүнг 2016 онтой харьцуулахад 23.4 хувиар буурсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

д/д	Ажлын төрөл	2016 онд батлагдсан ажил		2017 онд батлагдсан ажил	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Цахилгаан эрчим хүч нэмэгдүүлэх ажил	18	2,029.4	30	1,178.4
2	Авто засвар шинэчлэлийн ажил	8	1,247.2	33	1,709.4
3	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажил	43	5,856.2	20	1,661.5
4	Байгаль орчин, ногоон байгууламж, тохижилтын чиглэлээр хийх ажил	26	679.5	39	752.7
5	Барилга засварын ажил	89	10,169.2	73	7,839.2
6	Бараа худалдан авах	43	2,551.8	44	1,643.6
7	Төсөл хөтөлбөр			136	2,961.6
8	Бусад, зөвлөх үйлчилгээ	36	1,587.5	1	600.0
9	Авто замын сангаар	8	637.1	8	607.7
10					
	<b>Нийт ажлын дүн</b>	<b>271</b>	<b>24,757.9</b>	<b>384</b>	<b>18,954.1</b>


“Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар Орон нутгийн өмчийн газарт 1,024.6 сая төгрөгийн, ХББЗА ОНӨААТҮГ-т 491.3 сая төгрөгийн албан шаардлага, мөн СХАА-нд дотоод хяналт хэрэгжүүлэх 1 албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

➤ Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тус дансанд 2017 онд 1,938.1 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, 1,783.8 сая төгрөгийг зарцуулсан ба зарцуулаагүй үлдэгдэл 154.3 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад зардал 328.9 сая төгрөгөөр өссөн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 82.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь төсвийн шууд захирагч нарт зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэх, ТБОНӨХБАҮХАТХууль зөрчих, хамаарал бүхий этгээдэд давуу байдал үүсгэх нөхцлийг бүрдүүлж, чанаргүй хөрөнгө бэлтгэх, ашиглал үүсгэх боломж олгохоор байна.

Орлого, зардлыг хүснэгтээр харуулбал:

(сая.төгрөгөөр)



- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас орсон 45.01 сая төгрөг нь боловсролын салбарын байгууллагуудын эцэг эхийн хандивын орлого байна.

- ЗГНХ, ЗДНХ, ангилагдаагүй бусад зардлын орлого 1,122.61 сая төгрөгийн 218.7 сая төгрөг нь боловсролын байгууллагын, 850.9 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудын, 529.9 сая төгрөг нь бусад байгууллагуудын орлого байна.

- Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан орлогын 325.4 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагын орлого, 112.7 сая төгрөг нь боловсролын салбарын байгууллагуудын орлого, 110.3 сая төгрөг нь ГБХЗХГ-ын Залуучууд хөгжлийн хөтөлбөр, хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт, 3.8 сая төгрөг нь бусад байгууллагын орлого байна.

- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор нийт 131.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд үүний 73.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 26.1 сая төгрөгийг боловсролын салбарын байгууллагууд 29.3 сая төгрөгийг ГХБХБГ-аар, 2.9 сая төгрөгийн орлогыг бусад байгууллагууд бүрдүүлсэн байна.

- Урьд оны үлдэгдлээс санхүүжих орлого буюу 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар төсвийн байгууллагуудтай нэмэлт санхүүжилтийн хоорондын тооцоо нийлж 86.82 сая төгрөгийг буцаан олгохоор орон нутгийн нэгдсэн тайланд өглөг үүсгэж 2017 онд буцаан олгосон байна.

➤ Аймгийн Засаг даргын нөөц, бусад зардалд 5,208.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 4,994.8 сая төгрөгийг зарцуулж, 213.9 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлжээ. Аймгийн Засаг даргын нөөц, бусад зардлаас зарцуулсан зардлын талаар:

Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийг 80-100 хувь олгохоор тусгаж шилжүүлж байна. Энэ нь тус ажлыг хугацаандаа, үр дүнтэй, чанартай гүйцэтгэх, хийсэн ажлын тайлан, баримтыг бүрэн гүйцэд гаргуулан авч, үлдэгдэл санхүүжилтээр дамжуулан хяналт тогтоох, үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг

алдагдуулж байна. Тухайн хариуцлагагүй ТББ-ийн холбогдох хүмүүсийн зориулалт бусаар зарцуулсан үйл ажиллагаа болж хувирч байна. Нөгөө талаар ТББ-тай гэрээ байгуулж, хамтран ажиллаж буй хэлтэс албад тухайн ажилд зарцуулагдах зардлыг, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах зарчимд нийцүүлж үндэслэлтэй боловсруулдаггүй байна. Тиймдээ ч үлдэгдэл санхүүжилтийг авалгүй орхидог, гүйцэтгэлийн тайлан, баримтыг цаг хугацаанд нь бүрэн ирүүлдэггүй байна. Тухайлбал:

1. "Бүрэнбүстийн иргэн - Эрдэнэтийн хөгжил" ТББ-тай 3.0 сая төгрөгийн гэрээ байгуулж урьдчилгаа 2.4 сая төгрөг олгосон. Тус ТББ нь гүйцэтгэлийн тайлан, баримтад хонины шулсан мах, компот, шоколад, нухаш, талх, хэд хэдэн шатахууны баримт зэрэг хувийн хэрэглээний баримтуудыг хавсаргаж тайлан ирүүлсэн үлдэгдэл санхүүжилтийг аваагүй.

2. "Эрдэнэтийн эрхэм залуус" ТББ-тай 3.0 сая төгрөгийн гэрээ байгуулж урьдчилгаа 2.4 сая төгрөг олгосон. Тус ТББ нь мөн гүйцэтгэлийн тайлан, баримтыг дутуу ирүүлсэн, үлдэгдэл санхүүжилтийг аваагүй, ихэнх нь шатахууны баримт хавсаргасан.

3. "Бид зорилготой залуус" ТББ-тай 2.0 сая төгрөгийн гэрээ байгуулж урьдчилгаа 1.6 сая төгрөг олгосон. Холбогдох зурагтай, гүйцэтгэсэн ажлын тайлан ирүүлсэн боловч зарцуулалтын санхүүгийн баримт ирүүлээгүй, үлдэгдэл санхүүжилтийг аваагүй

Хамтран ажиллах гэрээ болон аймгийн Засаг даргын захирамжаар тус сангаас олгогдсон дараах ажлуудын гүйцэтгэл гараагүй, холбогдох арга хэмжээ зохион байгуулагдаагүй, төсвийн хөрөнгө үр ашиггүй, зориулалт бусаар нийт 6.4 сая төгрөг зарцуулагдсан байна.

1. Аймгийн Засаг даргын 2017.09.13-ны өдрийн А/538 тоот захирамжаар БСУГ-ын мэргэжилтэн Д.Отгонбаатарт "Вашингтоны монгол сум" байгууллагын урилгаар АНУ-ын Вашингтон хотод болох "Монголын од" бага хуралд оролцоход дэмжлэг үзүүлсэн 2.5 сая төгрөг. Тухайн арга хэмжээнд явж оролцоогүй, визэнд ороогүй.

2. "Монголын үндэсний гэрэл зураг, дүрс бичлэгийн хөгжил" ТББ-тай хамтран ажиллах гэрээний урьдчилгаанд /80%/ олгосон 3.9 сая төгрөг. Холбогдох үүргийн биелэлт хангагдаагүй, гэрээнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулаагүй, гэрээний ТББ-ын үүрэг болох 2.1-2.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Аймгийн ЗД-ын 2017.12.14-ны өдрийн А/738 тоот захирамжаар 13.9 сая төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Дотоод болон гадаад орнуудад зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн яармаг, бизнес форумд орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжин оролцуулах зардал"-аас гаргаж үр дүн, ач холбогдол багатай БНХАУ-ын Бээжин, Шиамин хотод тоног төхөөрөмжийн үзэсгэлэн худалдаа үзэх, туршлага судлуулахаар 7 хүнийг 3 хоногийн гадаад томилолт олгож явуулсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2017.11.01-ний өдрийн А/638 тоот захирамжаар "Маск Арт" ХХК-д 1.2 сая төгрөгийг "Орхон хууль эрх зүйн хэлтэс" нэртэй public тохиргоотой, фэйсбүүк пэйж хуудас нээж ажиллуулахад олгосон, хамтран ажиллах гэрээний дагуу "Эр Жи Ор" ХХК-д Erdenetmedeel.mn сайтын мэдээний үйлчилгээний хөлс 1.5 сая төгрөг олгосон боловч тус сайт нь google.mn-ээс хайлт хийхэд олдохгүй байна.

Аймгийн Засаг даргын 2017.12.25-ны өдрийн А/794 тоот захирамжаар 200.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад, төсөл хөтөлбөрийн зардлын данснаас Эрдэнэт санд төвлөрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө Сангийн сайдын 2012.11.15 -ны өдрийн 239 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3-д "Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх" гэсэн заалтын хүрээнд аймгийн Засаг даргын бүх захирамж гарч зарцуулагдсан байна. Тус хөрөнгийг зарцуулахдаа засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээгүй, зөвхөн Засаг даргын захирамжаар зарцуулж байна. Тухайлбал: Хүндэтгэл үзүүлэх, гарын бэлэг, дурсгалын зүйл гардуулах, зочин төлөөлөгч хүлээн авах, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэх, гадаад оронд айлчлах, олон улсын форумд оролцох, хөрөнгө худалдан авах, Засаг даргын орон тооны бус зөвлөхөд сар бүр урамшуулал олгох зэрэгт зарцуулсан байна. Үүнээс Цагдаагийн газрын дугуйт эргүүлд зориулж 8.0 сая төгрөгөөр худалдан авсан унадаг дугуйг хаана ч бүртгэлд авалгүй орхигдуулсан байна. Энэ нь дээрх журмын 2.3-д "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана", 3.1-д "Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна", 4.2-д "Тухайн шатны Засаг даргын Тамгын газар төсвийн зардлын тооцоог Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс /тасаг/- ээр хянуулан холбогдох газар, хэлтсээс санал авч, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй.

**3.2. Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн МОН-2301 төслийн зээл 7,446.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.**

Мөн Франц улсын хөрөнгө оруулалтаар Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл хэрэгжиж байгаа бөгөөд энэ төслийг эцсийн байдлаар орон нутаг хүлээж аваагүй байгаа тул хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд бүртгэлгүй, тайлбар тодруулгаар оруулсан байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

**Орон нутгийн төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, хянах шаардлагатай байна.**

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн байна.
- Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 сарын 17-ны өдрийн 5/03 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн төсөвт хийсэн тодотгол нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудтай нийцэхгүй байна.
- Орон нутгийн төсвийн тэнцлийг алдагдалгүй байхаар төлөвлөжээ.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 3016,5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 4 нэр төрлийн татварын орлого 2,4-46,8 хувиар буюу 1321,4 төгрөгөөр тасарсан байна.**

- Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээг бүрэн авч ажиллажээ.
- Татварын орлогыг 44,562.9 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 47,579.3 сая төгрөгийн орлого төвлөрч 3,016.5 сая төгрөгөөр давж биелэн гүйцэтгэл 106.8%-тай байна.
- Орлогын бүх гүйлгээ тухайн төсвийн захирагчийн төрийн сангаар дамжин хийгдсэн байна.

**Аймгийн 2017 оны төсвийн урсгал зардлыг нийт 4,367.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон ба гүйцэтгэлээр 735.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулжээ.**

- Төсвийн зарлагын гүйцэтгэл 735.5 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулагдсан байна.
- Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн МОН-2301 төслийн зээл 7446.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 3,016.5 сая төгрөгөөр давуулан биелүүлэн, төсвийн урсгал зардлыг 735.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулжээ.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөх нь:

Аймгийн ИТХ-д

1. Төсвийн орлогыг үнэн зөв, бодитой тооцоо судалгаанд, төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг хянаж, орон нутгийн төсвийн тодотголыг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалттай нийцсэн эсэхийг тодорхойлж тодотгож байхыг зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Батлут, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Бямбацэцэг нарт:

1. Орлогыг тооцоо судалгаатайгаар боломжит нөөц боломжоор бүрэн хамруулан төлөвлөж биелэлтийг ханган, бэлэн бус торгуулийн системээр ноогдуулсан торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн оруулах биелэлтэд тавих хяналтыг сайжруулах.
2. Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарцуулалтад гарч буй зөрчлийг давтан гаргахгүй, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгож, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ТАНИЛЦСАН:

Ц.НАРМАНДАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ


ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

Г.ОРГИЛМӨРӨН

**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ:**

Аймгийн Засаг дарга:







ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 12

Эрдэнэт хот

Г Тайлан баталгаажуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайлан /ОРА-2018/01/СТА-ТЕЗ/-г баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, зөрчлийн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, үр дүнгийн талаар 2018 оны 12 сарын 20-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Батлут/, аймгийн СТСХ-ийн дарга /Н.Бямбацэцэг/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад хүргүүлж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, санхүүгийн аудитын албаны ахлах аудитор /В.Жавзмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

201700259